МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ 1960

# ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД 2024 ОНД АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

*Улаанбаатар хот*

Эрүүл мэндийн яамны 2024 оны 3/859 дугаар
албан бичгийн хавсралтын дагуу

## АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.12.12

| Д/д | Хэрэгжүүлэх ажил | Хугацаа | Хариуцсан албан тушаалтан | Тайлан, нотлох баримт /Зураг, график, бусад/ |
|---|---|---|---|---|
| **Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх  үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | |
| 1.1. | АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | Жилийн турш | Хэвлэлийн дизайнер<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | АТГазар, АТГазрын олон нийтийн зөвлөлөөс бүтээсэн видео шторк болон зурагт хуудас зэргийг "Гэмтэл согог судлалын үндэсний төв" ФБ хуудсанд тогтмол байршуулж, нийтэд сурталчилж байна. АТГазраас ирүүлсэн зурагт хуудсыг тасаг нэгжүүдэд түгээж, самбарт байрлуулсан.<br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв<br>5 days ago ·<br>ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ТАНАА<br><br><br>Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв<br>19h ·<br>Одоо та юу хийж байна ирээдүй тийм л байдаг. Хүүхэд харснаа үйлдэж, сонссоноо ярьдаг, дууриадаг, бас суралцдаг. Үйлдэл бүрээ шударгаар хийгээд дадчихвал 10 жилийн дараа ч шударгаараа л үлдэнэ. Шударга нийгмийг ингэж л бүтээнэ...<br>#ЗөвЗөвдШударгаЗөв<br>#Авлигын_Эсрэг<br>#Залга110<br>#ШинэҮеАвлигыгТэвчихгүй<br><br><br>https://www.facebook.com/gemtelsogog/videos/854692515981258<br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | “Авлигад ҮГҮЙ гэж хэлье” аяны мэдээллийг 2024 онд үргэлжлүүлэн нийтэд түгээсэн бөгөөд АТГазар болон АТГазрын Олон нийтийн төвийн мэдээлэл, Авлигын талаарх гомдол санал өгөх 110 утасны дугаарыг цахим хуудсаар нийтэд хүргэж ажилласан.<br><br>ГССҮТөвийн ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТАСАГ, АМБУЛАТОРИЙН ТАСАГ, ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ тасгуудад байршуулсан 15 гаруй цахим дэлгэцээр иргэдэд АТГазар болон АТГазрын Олон нийтийн төвөөс гаргасан видео мэдээллүүдийг тогтмол хүргэж байна.<br><br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2. | АТГазар, ЭМЯамнаас зохион байгуулсан Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээнд байгууллагын онцлогт тохируулан оролцох, зохион байгуулах; | Жилийн турш | ГССҮТөвийн захиргаа<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг”-ийн гишүүд* | Авлигатай тэмцэх газраас улс даяар өрнүүлж буй “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх” аяны хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан таниулж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн видео контент, шторкийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр тасралтгүй түгээж, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж байгаа талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор холбогдох албан ёсны 2 ФБ хуудсыг дагаж, мэдээлэл авах уриалгыг зурагт хуудас байдлаар хийж, төвийн ФБ хуудсанд байршуулсан.<br><br>2024 онд “Авлигын эсрэг нэгдье” аяны хүрээнд 1 видео шторк хийж, ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ фб хуудсаар дамжуулан нийтэд хүргэлээ.<br><br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.3. | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах; | Жилийн турш | ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг”-ийн гишүүд* | ГССҮТөв бол Салбар эмнэлэгт “**Шударга ёс – Хөгжил дэвшилд 110**” самбарыг тус бүр нэгийг хийж, байршуулан Авлигын эсрэг хууль тогтоомж, Байгууллагын ил тод байдлын мэдээлэл болон Авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг үйлчлүүлэгчдэд хүргэж байна.<br>ГССҮТөвд байрлуулан ажиллуулж буй “ШУДАРГА ЁС ХӨГЖИЛ ДЭВШИЛД-110” самбар<br><br><br>ГССҮТөвийн Салбар эмнэлэгт байрлуулан ажиллуулж буй “ШУДАРГА ЁС ХӨГЖИЛ ДЭВШИЛД-110” самбар<br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.4 | Өөрсдийн үйл ажиллагаа авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгаа хийж олон нийтэд хүргэсэн байх; | 2024 оны 3-р улирал | ГССҮТөвийн захиргаа<br><br>Хэвлэлийн дизайнер<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | 2024 онд "Авлигын эсрэг нэгдье" аяны хүрээнд 1 видео шторк хийж, ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ фб хуудсаар дамжуулан нийтэд хүргэлээ.<br><br>12 сарын 10-ны байдлаар видео шторкыг 2000 гаруй хүн үзэж, 30 гаруй хүн лайк дарж, шейрлэсэн байна.<br><br><br><br> |

| **Хоёр. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах** | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1. | Шинээр томилогдсон албан тушаалтнууд болон бусад холбогдох албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх, ажилтнуудад ёс зүйн сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийн алба<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | 1. Цахим хуудсанд (gemtel.mn) Ёс зүйн дүрмийг байршуулж эмч, эмнэлгийн ажилчдад танилцуулан ажиллаж байна.<br>2. ГССҮТөвийн Хүний нөөцийн албаны ажилтнуудад зориулсан фейсбүүк группэд Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 тушаалаар шинэчлэн батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм", Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг эмч, эмнэлгийн ажилтнуудад танилцуулах зорилгоор шинэ ажилтны гарын авлагад оруулж, мөн цахим цуврал постер болгон нийтлэн оруулсан. |


Засгийн газрын 2019 оны
33 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ дүрмийн зорилго нь төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч (цаашид "төрийн албан хаагч" гэх)-ийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж болно.

1.3. Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, төрийн албан хаагч Төрийн албаны тухай хууль болон энэ дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

ГССҮТӨВИЙН ЁС ЗҮЙН САЛБАР ХОРОО




раа, Эрхэм зорилго, үнэт зүйл 5
рогг судлалын үндэсний төвийн товч түүх 6
н бүтэц зохион байгуулалт 8
бадын чиг үүрэг 14
БҮЛЭГ 05 Давхруудын байршил, схем 38
БҮЛЭГ 06 Хөдөлмөрийн дотоод журам 42
БҮЛЭГ 07 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм 83
БҮЛЭГ 08 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд мөрдөх нийтлэг журам 100
БҮЛЭГ 09 Аюулгүй ажиллагааны зааварчилгаа 110
БҮЛЭГ 10 Нийтлэг асуулт 130

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br><br>3. Зөрчил үүссэн буюу үүсэж болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх, сургалт явуулах, эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авдаг. Үүнд: 2024 оны 1-11 сарын хооронд салбар хороонд ирсэн ажилтан болон үйлчлүүлэгчээс ирсэн 9 өргөдөл, гомдлын 7-ыг эвлэрүүлэн зуучилсан, Ёс зүйн алдаа тогтоогдсон **1 эмчид сахилгын шийтгэл оногдуулсан**, БГД-н цагдаагийн 1-р хэлтэст шалгагдаж байгаа 1 зөрчлийг шийдвэрлэх боломжгүй тул буцаасан.<br>4. 2024 онд Ёс зүйн салбар хорооны дарга О.Цэрэндорж, Г.Бадамгарав, А.Цэрэндолгор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм сэдэв”-т сургалтыг төв болон салбар эмнэлэгт 4 удаа зохион байгуулсан.<br>Ажилтнуудын харилцаа хандлага, үйлчилгээний соёлыг сайжруулах үүднээс дараах сургалтыг зохион байгуулсан.<br>1. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”<br>“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” /2019 оны А/406<br>“Сувилагч мэргэжилтний ёс зүйн дүрэм”<br>“Үйлчилгээний соёл, харилцаа хандлага”<br>"Эмч, эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны ур чадвар"<br>5.“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандарт”<br>6."Эмч, эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны ур чадвар"-ыг сайжруулах чиглэлээр нийт 15 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | удаагийн сургалтыг зохион байгуулж төвийн 980 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.<br>5. Тайлант оны 1-11 сард шинээр ажилд орсон нийт 220 ажилтанд тухай бүр Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж ажилласан.<br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ГССҮТөвийн Салбар эмнэлэгт зохион байгуулсан сургалт<br><br><br> |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>Монгол улсын их хурлын хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 тоот тогтоолын тухай 2024 оны 5-р сарын 8-ны өдөр зохион байгуулагдсан Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад хамрагдсан.


</td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.2. | Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах; | Жилийн турш | ГССҮТөвийн захиргаа<br><br>Эдийн засаг төлөвлөлт маркетингийн алба<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | Байгууллагын худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдээс "АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ" тайлбарыг тогтмол гаргуулан авч байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар 23 үнэлгээний хорооны 121 гишүүнээс дээрх мэдэгдэл тайлбарыг авч, АТГазрын цахимд оруулсан ба ашиг сонирхлын зөрчил бүртгэгдээгүй байна. ГССҮТөв нь ямар нэгэн тусгай зөвшөөрөл олгодоггүй болно.<br><br><br><br>"ОНЧ ШИЙДЭЛ" ТББ-аар 2025 оны 1-р улиралд "Авлигын эрсдэлийн үнэлгээ" хийлгэхээр гэрээ байгуулаад байна. |

<table>
<tr><td colspan="5">Гурав. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</td></tr>
<tr>
<td>3.1.</td>
<td>Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;</td>
<td>Жилийн турш</td>
<td>ГССҮТөвийн захиргаа<br><br>Эдийн засаг төлөвлөлт маркетингийн алба<br><br>Хуулийн зөвлөх<br><br>Санхүү бүртгэлийн алба</td>
<td>ГССҮТөвийн худалдан авах үйл ажиллагаанд оролцдог үнэлгээний хорооны гишүүдэд Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам зааврыг мөрдөх талаар сургалт, зөвлөн туслах үйлчилгээ авах гэрээг Худалдан авах ажиллагааны зөвлөх ажилтан, эдийн засагч Н. Цэнд-Аюуштай байгуулан хэрэгжүүлж байна.<br><br><br>БАТЛАВ:<br>"ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"<br>ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ<br><br>БАТЛАВ:<br>ИРГЭН : Н.ЦЭНД-АЮУШ<br><br>ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ<br>2024 оны 04 дүгээр сарын 25 өдөр  № 24/12  Улаанбаатар хот<br><br>Энэхүү хөлсөөр ажиллах тухай гэрээ /Цаашид "Гэрээ" гэх/-г Нэг талаас: 9077219 регистрийн дугаартай Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Нөгөө талаас Н.Цэнд-Аюуш (УХ68111806 ) /цаашид "гүйцэтгэгч" гэх нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав. Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг хоёр тал харилцан хүлээн зөвшөөрөв.<br><br>Нэг. Нийтлэг үндэслэл<br>1.1 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.2-г заасан үйлчилгээг үзүүлэх. Захиалагч нь энэхүү гэрээгээр хэлэлцэн тохиролцсон төлбөрийг Гүйцэтгэгч талд төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.<br>1.2 Гүйцэтгэгч нь дараахь үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахад хууль, журам зааврын шинэчлэлийн талаар холбогдох албан тушаалнуудад сургалт хийх, зөвлөгөө өгөх;<br>• Тус байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сонгон шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулах талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх;<br>• Тендерийн баримт бичгийг хууль, журам, зааврын дагуу боловсруулахад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх<br>• Тендерийн гүйцэтгэл үр дүнг хүлээн авах, хяналт тавих, үнэлэх талаарх зөвлөх үйлчилгээ үзүүлэх<br>1.3 Гүйцэтгэгч нь зөвлөх үйлчилгээг 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийг хүртлэх хугацаанд 8 удаа тус төвд очиж зөвлөх үйлчилгээ үзүүлэх ба шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр ГССҮТөвийн үнэлгээний хорооны гишүүдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ.<br><br>Хоёр. Ажлын хөлс<br>2.1 Гүйцэтгэгчийн нийт ажлын хөлс 4,000,000 (дөрвөн сая) төгрөг байна.<br>2.2 Гүйцэтгэгч гэрээний 2.1-д заасан үнийн дүнгээс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцаж төлнө.<br>2.3 Захиалагч нь энэ гэрээний 2.1-т заасан ажлын төлбөрийн 50 хүртэл хувийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоногийн дотор үлдсэн 50 хүртэл хувийг үйлчилгээг бүрэн</td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Н.Цэнд-Аюуш зөвлөх нь зөвлөх үйлчилгээг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд А3 сертификат бүхий үнэлгээний хорооны гишүүдэд 8 удаагийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ба шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр ГССҮТөвийн үнэлгээний хорооны гишүүдэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.<br>Энэ ажлын хүрээнд тендер шалгаруулалт зохион байгуулахын өмнө техникийн тодорхойлолт, бараа, ажил, үйлчилгээний захиалга даалгаврыг холбогдох нэгжээс хүлээн авч тэрхүү захиалга даалгавар, техникийн тодорхойлолт, нийлүүлэлтийн хуваарь, зааварчилгааны дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах нь Үнэлгээний хороодыг эрсдэлээс хамгаалах боломжтой талаар зөвлөн зааварчилсан. |
| 3.2. | “**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**”-ыг хэрэгжүүлэх; | | ГССҮТөвийн захиргаа<br><br>Эдийн засаг төлөвлөлт маркетингийн алба<br><br>Хуулийн зөвлөх<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг”-ийн гишүүд* | Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөний дагуу 2024 оны 5-р сард ГССҮТөвийн нийт удирдлага, тасаг албадын дарга, ахлах сувилагч нар, захиргааны ажилтнуудыг хамруулсан сургалт зохион байгуулсан.<br> |

БАТЛАВ: ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах

2023-11-02

| № | Журмын үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх ажил | Хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй байдал | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан ажлын байрны сул орон тоо, сонгон шалгаруулах журам, Төсвийн гүйцэтгэлийн биелэлт, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, шилэн дансны мэдээлэл зэрэг холбогдох нээлттэй мэдээллүүдийг байгууллагын вэб сайт, цахим хуудсанд заагдсан хугацаанд зарчмын дагуу мэдээлэх, тайлагнах | Жилийн турш | Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Б.Батзориг<br>МТАлбаны дарга Э.Батдорж<br>СБАлбаны дарга Ц.Энхбаяр<br>ХНАлбаны дарга А.Цэрэндолгор<br>Хэвлэлийн ажилтан Б.Нарангэрэл |
| 2 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал | Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан мэдээллүүдийг заагдсан хугацаанд тавигдсан зарчимд нийцүүлэн мэдээлэх | Жилийн турш | СБАлбаны дарга Ц.Энхбаяр<br>Шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтан Э.Чинтогтох |
| 3 | Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дугаар зүйлийн 6.1-д заасан төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилт | Авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа явуулах, АТГазар, Олон нийтийн зөвлөлөөс гаргаж байгаа мэдээлэл, зөвлөмжийг түгээх | Жилийн турш | Хэвлэлийн ажилтан Б.Нарангэрэл<br>ЭБАТ Б.Түмэн-Өлзий |

БАТЛАВ: ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ

**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**Зорилго:** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналт хэрэгжүүлэх журмын талаар болон бусад холбогдох мэдээллийг ГССҮТөвийн албан тушаалтнууд болон мэргэжилтнүүдэд хүргэх

**Хугацаа:** 2024 оны 5 сарын 30-ны 12.00 цагт ГССҮТөвийн хурлын танхимд

**Оролцох ажилтнууд:** ГССҮТөвийн захирал, дэд захирлууд, тасгийн эрхлэгч, албадын дарга, ахлах сувилагч нар, бүх албадын мэргэжилтнүүд нийт 124 хүн оролцоно.

| № | Сургалтын агуулга | Хугацаа | Хариуцсан ажилтан |
|---|---|---|---|
| 1 | Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам /МУ-ын ЗГ-ын 2021 оны 109 тоот тогтоол/ | 12.00-12.30 | “Онч шийдэл” ТББ-ын тэргүүн, хуульч Ш.Алтангадас |
| 2 | Авлигын эрсдэлийн үнэлгээ | 12.30-13.00 | “Онч шийдэл” ТББ-ын хуульч Б. Цэрэнлхам |
| 3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбар гаргах | 13.00-13.30 | ГССҮТөвийн ЭБАТ Б.Түмэн-Өлзий |

Хөтөлбөр боловсруулсан: ЭБАТ Б.Түмэн-Өлзий

Хянасан: Хуулийн зөвлөх Б.Билгүүн

2024-05-20

ГССҮТөвийн удирдлага, тасгийн эрхлэгч, албадын дарга, ахлах сувилагч нар болон захиргаа санхүүгийн нийт ажилтнуудад Засгийн газрын 2021 оны 109 тоот тогтоолоор батлагдсан “**Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын хэрэгжүүлэх журам**”-ын талаар “Онц шийдэл” ТББ-ын тэргүүн Ш. Алтангадас, “**Авлигын эрсдэлийн үнэлгээ**”-ний тухай сургалтыг “Онц шийдэл ТББ-ын хуульч Б. Цэрэнлхам нар хийлээ.

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | |  |


2024 оны 5 сарын 30-ны өдрийн 12.00 цагт
В1 хурлын танхимд "Онч шийдэл" төрийн бус байгууллагын тэргүүн хуульч Ш.Алтангадас, хуульч Б.Цэрэнлхам нар "ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ, АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ"-ний талаар сургалт зохион байгуулах тул тасгийн эрхлэгч, албадын дарга нар болон захиргаа, бусад дэмжих албадын ажилтнууд бүрэн хамрагдана уу.
Жич: Салбар эмнэлгийн ажилтнууд цахимаар холбогдоно.


Ш Алтангадас
Хуульч (LL.M)


Эрх зүйн үндэслэл

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br><br>Уг сургалтанд ГССҮТөвийн удирдлага, тасгийн эрхлэгч, албадын дарга, ахлах сувилагч нар болон захиргааны дэмжих албадын ажилтан мэргэжилтнүүд нийт 100 гаруй ажилтан, албан тушаалтнууд хамрагдлаа. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br><br>ГССҮТөвд Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх орон тооны бус ажилтны сонгон шалгаруулалт зарлаж, зарыг байгууллагын вэб хуудсанд байршуулсан бөгөөд одоогийн байдлаар 2 хүний мэдээлэл Хүний нөөцийн албанд ирээд байна. Сонгон шалгаруулалтыг хийж, захирлын тушаалаар хяналт хийх ажлын хэсгийн тушаал гарах юм. |

| Дөрөв. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | |
|---|---|---|---|---|
| 4.1. | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Жилийн турш | ГССҮТөвийн захиргаа<br><br>ЭМТҮЧАБАлба<br><br>Мэдээлэл технологийн алба<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | ГССҮТөвд Осол гэмтлийн яаралтай тусламжийг 24 цагийн турш үзүүлдэг бөгөөд Амбулаторийн тусламжийг ажлын өдрүүдэд 8 цагаар үзүүлдэг болно. Амбулаторийн үзлэгийн цагийг тус төвийн Цахим бүртгэл дээр биеэр ирж авч болохоос гадна Дуудлагын төвийн **1800-0119** дугаарын утсаар цаг авах боломжийг бүрдүүлсэн ба энэ төвөөр сард дунджаар 1000 орчим үйлчлүүлэгч үзлэгийн цаг авч, тэдгээрийн 80% нь эмнэлэгт ирж, тусламж үйлчилгээ авсан байна.<br>Байгууллагын ФБ хуудас, вэбсайт **gemtel.mn** хаягаар тусламж үйлчилгээ, үзлэгийн цаг олголт, түгээмэл асуултуудтай холбоотой асуултад хариулах зэргээр мэдээллийг тогтмол хүргэж хэвшсэн байна.<br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.3. | Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах; | Улиралд тутамд | ГССҮТөвийн захиргаа<br><br>ЭМТҮЧАБАлба<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартад заагдсан аргачлалын дагуу сэтгэл ханамжийн судалгааг цахим мэдээллийг суваг, QR код, https://docs.google.com, хэвлэмэл хуудас болон бусад хэлбэрийг ашиглан түүврийн дагуу Хэвтэн эмчлүүлэх 8 тасгийн 106 үйлчлүүлэгч, Амбулаторийн тасгийн 26, Яаралтай тусламжийн тасгийн 31, нийт 163 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгааны асуумж нь:<br>1. Ерөнхий асуумж /нас хүйс гм/<br>2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл<br>3. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал<br>4. Байгууллагын соёл<br>**5. Тэгш байдал, ашиг сонирхол**<br>6. Ерөнхий сэтгэл ханамж<br>7. Санал хүсэлт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.<br><br>2024 оны Сэтгэл ханамжийн судалгааг цаасан болон цахим Qr 2 хэлбэрээр авч ажилласан ба тус судалгааны 5 дугаар бүлэг "**Тэгш байдал, ашиг сонирхол**"-ийг дараахь асуултаар судалгаа авсан.<br>• Тусламж үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гарсан уу?<br><br>• Эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй байсан уу?<br><br>• Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах хугацаанд гаднаас эмчилгээнд хэрэгтэй зүйлс авчрахыг Танд зөвлөсөн үү?<br><br>гэсэн асуултын хүрээнд үнэлгээг Хэвтэн эмчлүүлэх 8 тасаг, Амбулаторийн тасаг, Яаралтай тусламжийн тасгийн хэмжээнд судалгааг авсан. Үүнд нийт үйлчлүүлэгчдийн 93 % /2023 онд 90%/ ашиг сонирхолын зөрчилгүй тусламж үйлчилгээ үзүүлсэн гэсэн дүгнэлт гарсан байна.<br><br>Тавдугаар бүлэг буюу "**Тэгш байдал, ашиг сонирхол**" хэсгийн үр дүнгээс хавсаргав. |

ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТАСАГ




| Асуулт | Тийм | Үгүй | Мэд-й | Нийт | CSAT хувь | 2023 он 1-11 сар |
|---|---|---|---|---|---|---|
| Тусламж үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гарсан уу? | 6 | 250 | 10 | 266 | 94.0% | 88.0% |
| Эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй байсан уу | 13 | 275 | 8 | 296 | 92.9% | 94.1% |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах хугацаанд гаднаас эмчилгээнд хэрэгтэй зүйлс авчрахыг Танд зөвлөсөн уу? | 26 | 266 | 3 | 295 | 90.2% | |
| Нийт | 45 | 791 | 21 | 857 | 277.1% | 182.0% |
| | 5% | 92% | 2% | 100% | 92.3% | 91.0% |

2024 оны эхний 11 сарын сэтгэл ханамжийн судалгаагаар "Хэвтүүлэн эмчлэх тасаг"-уудын "Тэгш байдал, ашиг сонирхол" бүлгийн асуултын үнэлгээ 2023 онд 91% байсан бол 2024 онд 92.3% болж, 1.3%-р сайжирсэн үзүүлэлттэй байна.

АМБУЛАТОРИЙН ТАСАГ




| Асуулт | Тийм | Үгүй | Мэд-й | Нийт | CSAT хувь | 2023 он 1-11 сар |
|---|---|---|---|---|---|---|
| Тусламж үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гарсан уу? | 3 | 125 | 4 | 132 | 95% | 89.3% |
| Эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй байсан уу | 11 | 136 | 2 | 149 | 91% | 83.3% |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах хугацаанд гаднаас эмчилгээнд хэрэгтэй зүйлс авчрахыг Танд зөвлөсөн уу? | 14 | 124 | 0 | 138 | 90% | |
| Нийт | 28 | 385 | 6 | 419 | 276% | 172.6% |
| | 7% | 92% | 1% | 100% | 92% | 86.3% |

2024 оны эхний 11 сарын сэтгэл ханамжийн судалгаагаар "Амбулаторийн тасаг"-ийн "Тэгш байдал, ашиг сонирхол" бүлгийн асуултын үнэлгээ 2023 онд 86.3% байсан бол 2024 онд 92% болж, 5.7%-р сайжирсэн үзүүлэлттэй байна.

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТАСАГ




2024 оны эхний 11 сарын сэтгэл ханамжийн судалгаагаар “Яаралтай тусламжийн тасаг”-ийн “Тэгш байдал, ашиг сонирхол” бүлгийн асуултын үнэлгээ 2023 онд 93% байсан бол 2024 онд 94.3% болж, 1.3%-р сайжирсэн үзүүлэлттэй байна.




ЗӨВЛӨМЖ

Эмнэлгийн нийт дүнгээр 2024 оны эхний 11 сарын үзүүлэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3% сайжирсан үзүүлэлттэй байна. Сэтгэл ханамжийн судалгааны эдгээр үр дүнг нийт эмч мэргэжилтнүүдэд танилцуулж, үр дүнг сайжруулах зөвлөмжийг ЭМТҮЧАБАлбанаас хүргэв.

| Тав. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | |
|---|---|---|---|---|
| 5.1. | Удирдлагын зүгээс тухайн оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн оны 1-р улиралд баталж, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах; | | ГССҮТөвийн захиргаа<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* | ЭМЯамны 2023 оны 2/878, 2024 оны 3/859 албан бичгийн хавсралтад тусгасны дагуу ГССҮТөвд 2024 онд хэрэгжүүлэх Авлигын эсрэг ажлын төлөвлөгөө боловсруулж, Ерөнхий захирал батлан хэрэгжүүлж байна. |

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр, Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2023.03.02 № 2/878
танай ________-ны № ________-т

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны батлагдсан төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Та бүхний Эрүүл мэндийн сайдтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллага бүр Авлигын эсрэг төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээр тусгасан. Иймд хавсралтаар хүргүүлсэн төлөвлөгөөнд тусгагдсан бүх арга хэмжээг байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заавал тусгахын зэрэгцээ уг төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч шаардлагатай нэмэлт арга хэмжээг тусган баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн тайланг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн, жилийн эцсийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ТӨГСДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр, Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2024.02.29 № 3/859
танай ________-ны № ________-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны батлагдсан төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Та бүхний Эрүүл мэндийн сайдтай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллага бүр Авлигын эсрэг төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээр тусгасан. Иймд хавсралтаар хүргүүлсэн төлөвлөгөөнд тусгагдсан бүх арга хэмжээг байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заавал тусгахын зэрэгцээ уг төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч шаардлагатай нэмэлт арга хэмжээг тусган баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн, жилийн эцсийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 4 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА С.ЭРДЭНЭТУЯА

Эрүүл мэндийн яамны 2023 оны 2/878 дугаар албан бичгийн хавсралтын дагуу

БАТЛАВ.
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023-2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023-03-13

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд **сурталчлах, соён гэгээрүүлэх** үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) | Хэвлэлийн ажилтан<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* |
| | | 1.2.АТГазар, ЭМЯамнаас зохион байгуулсан Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээнд байгууллагын онцлогт тохируулан оролцох, зохион байгуулах; | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | ГССҮТөвийн захиргаа<br><br>ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах; | -Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | ЭБАТ<br><br>*ГССҮТөвийн ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажил зохион байгуулах баг"-ийн гишүүд* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Мөн Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгаврын "БАЙГУУЛЛАГАД АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСЭХ ЭРСДЛИЙГ АРИЛГАХ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, ХҮНД СУРТАЛ, ШУДАРГА БУС БАЙДАЛ ГАРГАХГҮЙ БАЙХ ТАЛААР СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ" ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Ерөнхий захирлын 2023 оны 01 сарын 16-ны А/08 тоот тушаалаар баталж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, улирал бүр үр дүнгээ тайлагнаж байна.<br><br>ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ<br>ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН<br>ТУШААЛ<br>2023 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/08 Улаанбаатар хот<br><br>Ажлын хэсэг байгуулах тухай<br><br>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.6 дахь заалт, Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:<br><br>1. Гэмтэл согог судлалын төвийн хэмжээнд мөрдөх "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах ажлын хэсэг"-ийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.<br>2. Хавсралтаар баталсан ажлын хэсэг, багийн ажиллах төлөвлөгөө, тайланд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал (Р.Гантуяа), ажлын хэсгийн гишүүдийг удирдлагаар хангаж ажиллахыг Эрдэм шинжилгээ инноваци хариуцсан дэд захирал (Б.Батзориг) нарт тус тус даалгасугай.<br>3. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөний дагуу төвийн нийт эмч, эмнэлгийн ажилчид мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгосугай.<br><br>ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5.4. | Салбарын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд чанарын хяналт хийнэ. | | | 2024 онд ГССҮТ-д нийт 100 өргөдөл, гомдол ирсэн. **Үүнээс:**<br>• 11-11 төвөөр -62 /62%/<br>• Бичгээр –25 /25%/<br>• Албан бичгээр -3 /3%/<br>• Цахимаар – 10 /10%/<br>• Утсаар – 0 /0%/<br>Хугацаа хэтрүүлсэн, шийдвэрлээгүй өргөдөл, гомдол үгүй. Авлига, ашиг сонирхолтой холбоотой өргөдөл, гомдол 2024 онд бүртгэгдээгүй байна. ГССҮТ-н 2024 оны өргөдөл, гомдлын тайланг хавсаргав. Ирсэн гомдлыг хянан тодруулж, 1 эмчид сануулах, 1 эмчид цалингийн арга хэмжээ авч, бусад ажилтнуудад холбогдох хууль журмын талаар зөвлөгөө зөвлөмж өгч, анхааруулсан байна. |




| Өргөдөл, гомдлын хэлбэр | 2024.01-11 | | 2023 он | |
|---|---|---|---|---|
| | 100 | 100% | 124 | 100% |
| 11-11 төвөөр | 62 | 62% | 63 | 50.81% |
| Бичгээр | 25 | 25% | 30 | 24.19% |
| Албан бичгээр | 3 | 3% | 0 | 0% |
| Цахимаар | 10 | 10% | 4 | 3% |
| Утсаар | 0 | 0% | 4 | 3.23% |
| Бусад | 0 | 0% | 23 | 18.55% |
| Нийт | 100 | 100% | 124 | 100% |

| | | |
|---|---|---|
| ТАЙЛАГНАСАН: | ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын албаны дарга | Б.Бат-Оргил |
| | Хүний нөөцийн албаны дарга | А.Цэрэндолгор |
| | Санхүү бүртгэлийн албаны дарга | Ц.Энхбаяр |
| | Эдийн засаг төлөвлөлт, маркетингийн албаны дарга | Э. Сайнбилэг |
| | Мэдээлэл технологийн албаны дарга | Э.Батдорж |
| | Ёс зүйн салбар хорооны дарга | О.Цэрэндорж |
| | Хэвлэлийн ажилтан | Б.Нарангэрэл |
| | ЭМТҮЧАБАлбаны мэргэжилтэн | Э.Золбоо |
| НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН: | ГССҮТөвийн ЭБАТ | Б.Түмэн-Өлзий |
| ХЯНАСАН: | Захирал | Э.Галбадрах |